



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



МОНГОЛ
УЛСЫН
ИХ
СУРГУУЛЬ

ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

2004 № 1

232 (09)



Улаанбаатар хот

Тус сэтгүүл нь анх 1996 оноос "Алтан аргамж" нэрээр, 2002 оноос "Олон улсын харилцаа" нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as "Altan argamj" and since 2002 as "World Affairs"

Сэтгүүлийн зөвлөл:

Editorial Board:

Эрхлэгч:

Editor in Chief:

Н.Алтанцэцэг (проф.доктор Ph.D)

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Assistant Editor:

Д.Тунгалаг (дэд проф.доктор Ph.D)

D.Tungalag (Prof.Ph.D)

Гишүүд:

Members:

Ж.Баясах (тэр.проф.доктор Ph.D)
Ц.Гүрбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
С.Отгонбаатар (дэд проф.доктор Ph.D)
Ж.Бор (проф.доктор Ph.D)
Л.Даваадэлгэр Ахлах багш

J.Bayasakh (Prof.Ph.D)
Ts.Gurbadam (Prof.Ph.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
S.Otgonbaatar (Prof.Ph.D)
J.Borr (Prof.Ph.D)
L.Davaadelger Senior Lecturer

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Typist:

С.Энхцэцэг

S.Enkhtsetseg

Сэтгүүлийн хаяг:

Editorial Address:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн салбар – 46 а, хайрцаг-6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 311809; 318640; 328623
Факс: (976-11)319245
E-mail: admin_sfs@mongol.net

School of Foreign Service
Mongolian National University
P.O. – 46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel: 311809; 318640; 328623
Fax: (976-11) 319245
E-mail: admin_sfs@mongol.net

I. Гадаад бодлого, Монгол улсын гадаад харилцаа: түүх, орчин үе

1. Ж.Баттөр	
Гадаад бодлогын онолын асуудалд	5
2. С.Энхцэцэг	
ОХУ-ын гадаад бодлого дахь олон нийтийн дипломат ажиллагаа	9
3. Д.Уламбаяр	
Японы ноёрхлын үеийн Солонгосын хойг, түүний гадаад орчин	17
4. Н.Төмөр	
Елюй Чуцай, Чанчунь Бомбо хоёрын харилцаа	38
5. Д.Уламбаяр	
Өрнөдийнхөн Монголын хаадтай харилцсан нь	44
6. Ж.Бор	
Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн Монголын төрийн дипломат албанд гүйцэтгэсэн түүхэн үүрэг	60
7. Ц.Гурбадам	
Ю.Цэдэнбал Монгол улсын тусгаар тогтнолын асуудалд хэрхэн хандаж байсан тухай	64
8. Б.Цолмон	
Соёлын даяаршил Монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь	75

II. Олон улсын эдийн засгийн харилцаа

9. Д.Баажийхүү	
Монголын эдийн засаг, ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа	85
10. Д.Начин	
Монгол улсын эдийн засгийн гадаад бодлогын хэрэгжилт: Гадаадын хөрөнгө оруудалт	107
11. А.Ичинхорлоо	
Интеграцилал ба олон улсын маркетингийн орчин	122
12. А.Ичинхорлоо	
Аккредитаци, сертификатчилалын олон улсын хэмжээн дэх зохицуулалт	126

III. Олон улсын эрх зүй

13. Хуан Сон Гүн	
Олон улсын эрүүгийн нээлттэй шүүхээр шийдвэрлэх хууль ёсны асуудалд	130
14. Хуан Сон Гүн	
Хусейны хэргийг нээлттэй шүүхээр шийдвэрлэх хууль ёсны асуудалд	141
15. Ж.Оймандах	
Бараа худалдах ба худалдан авах олон улсын гэрээний асуудалд	145

IV. Сурвалж бичиг

16. Д.Уламбаяр	
“Монголын нууц товчоо”- улс төрийн сургаалын эртний дурсгалт бичиг мөн	149

ГАДААД БОДЛОГЫН ОНОЛЫН АСУУДАЛД

Ж.Баттөр*

АНУ-ын судлаач, олон улсын харилцааны томоохон эрдэмтэн К.Ж. Холсти олон улсын бодлогын задлан шинжилгээний арга зүйн талаар бичсэн нэгэн алдартай бүтээлдээ: “Аливаа орны гадаад бодлогын зорилго нь:

1. Тусгаар тогтнолоо сахин хамгаалах;
2. Аюулгүй байдлаа хадгалж, баталгаатай болох;
3. Нийгмийн халамж;
4. Улс орны нэр хүнд;
5. Үзэл санаагаа сахих, баримтлах, өсгөн өргөжүүлэх, хүчин

чадлаа хадгалах хийгээд өргөжүүлэхэд тус тус оршдог” гэжээ.¹

Түүнчлэн Падельфорд, Линкольн нар гадаад бодлогын зорилго болон сэдлийг:

1. Аюулгүй байдал;
2. Эдийн засгийн цэцэглэлт болон өрнөлт;
3. Гадаад талбар дахь улс төрийн тогтвортой байдал, түүнийгээ хадгалах, улс төрийн зорилгодоо хүрэх чадвар гэж тодорхойлсон.²

Өмнөд Солонгосын профессор Ким Ён Жаг гадаад харилцааны зорилгыг нэлээд нарийвчлан авч үзсэн байдаг. Тэрбээр энэхүү зорилгыг дор дурдсан байдлаар тайлбарлажээ. Үүнд:

1. Улс төрийн зорилгын хувьд “тусгаар тогтнолоо хадгалах”, “хүлээн зөвшөөрөгдөх”, “улс орныхоо нэр хүндийг өргөх”;
2. Эдийн засгийн талаар “улс үндэстнийхээ эрх ашгийг хадгалах, өргөжүүлэх” болон “хөгжил цэцэглэлт”;

* МУИС, ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

3. Цэргийн талаар “аюулгүй байдлаа ханган баталгаажуулах” ба үүний тулд “хүчин чадлаа хадгалах, дээшлүүлэх”;
4. Бүхий л салбарт улс орны зорилгодоо хүрэх, улс орондоо нэр хүнд олох, үүргээ өргөжүүлэхийн төлөө “гадаад улс орнуудтай найрамдал, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх” болон “холбоо тогтоох” явдал болно.³

Гэхдээ аливаа улсын дотоод, гадаад онцлог, тулгамдсан асуудал, цаг үеийн байдал зэргээс үүдэн гадаад бодлогын зорилго нь өвөрмөц шинжтэй байдаг. Эндээс гадаад бодлогын зорилго болоод түүнийгээ хэрэгжүүлэхэд нь гадаад ба дотоод орчин онцгой нөлөөтэй. Жосеф Франкел тэдгээр орчинг дараах маягаар ангилжээ.⁴

А. Гадаад орчин:

1. Улс орнууд буюу олон улсын хамтын нийгэмлэг болон улс орны эрх ашиг;
2. Физик орчин;
3. Нийгмийн орчин;
4. Нэгдэн буй дэлхий;
5. Өөрчлөлтүүдийн нөлөө;

Б. Дотоод орчин:

1. Иргэдийн үүрэг роль;
2. Олон нийтийн мэдээллийн тогтолцоо;
3. Улс төрийн нам, шахалт үзүүлдэг бүлэглэлүүд болон эрх мэдэл бүхий бүлэглэл гэж дурджээ.

Аливаа улсын гадаад бодлогыг ойлгох, дүгнэж цэгнэх, онцлогийг нь танин мэдэхэд тодорхой жишиг хэрэгтэй байдаг. Тэрхүү жишигийг Жосеф Франкел тогтоохдоо:

1. Газар зүйн байрлал ба түүхэн уламжлалаас улбаатай харьцангуй үргэлжилсээр ирсэн элементүүд;
2. Гадаад бодлогын шийдвэр гаргадаг байгууллагын өвөрмөц онцлог
3. Гадаад бодлогын гол чухал зорилт болон оролцох хэрэглүүр,
4. Голлох улс орон ба блокын талаархи хандлага,
5. Олон улсын дэг журмын талаархи хандлага⁵ гэж үзсэн байна.

Японы судлаач Ханай Хитоши, Сүдо Такаши нар хамтарсан судалгаандаа Япон, Хятад, Өмнөд Солонгос зэрэг нийт 17 орны гадаад бодлогыг харьцуулан судлаад гадаад бодлогод харьцуулсан шинжилгээ хийх аргачлалыг боловсруулсан байна.

Үүнд:

1. Гадаад бодлогын хүчин зүйлс:

- Газар зүй;
- Улс орны хүчин чадал, (хүний чадавхи, байгалийн баялаг, эдийн засаг, цэрэг, технологийн төвшин);
- Улс төр, эдийн засгийн тогтолцоо;
- Түүх, соёлын хүчин зүйлс;

2. Засаглалын шийдвэр гаргах явц:

- Засгийн газрын хүрээнд (Засаг захиргааны хүрээ, хууль тогтоох хүрээ, хууль хэрэгжүүлэх хүрээ);
- Засгийн газрын бус хүрээнд (улс төрийн нам, шахалт үзүүлдэг бүлэглэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, ард иргэдийн үзэл бодол);

3. Гадаад бодлогын хэв маягийн онцлог:

- Газарзүйн хүчин зүйлсээс үүдэлтэй онцлог;
- Улсын хүчин чадлын төвшингээс үүдэлтэй онцлог;
- Улс төр, эдийн засгийн тогтолцооноос үүдэлтэй онцлог;
- Түүх, соёлын хүчин зүйлсээс үүдэлтэй онцлог;
- Бусад онцлог.⁶

Үүнээс үзэхүл аливаа хоёр орны харилцааг судлана гэдэг багагүй хүчин зүйлсийг харьцуулан нягталж, системчлэн үзэх шаардлагатай болох нь харагдаж байна. Манай оронд үнэндээ гадаад бодлогын онолын асуудал төдийлэн хөгжөөгүй байгааг энд тэмдэглэхэд илүүдэхгүй болов уу.

Олон улсын харилцаа, гадаад бодлогын дэг сургуулийн талаар ихээхэн судалгаа буй. Энд зохиогч гадаад бодлогын зорилгыг ангиллын үүднээс авч үзэхийг оролдсон болно.

Ишлэл, тайлбар:

1. K.J. Holsti, *International Politics; A. Framework for Analysis* (Englewood Cliffs: Prentice-Hall, 1977. pp-145-152.
2. Norman J. Padelford & George A. Lincoln, *The Dynamics of International Politics*, New York, Macmillan, 1962
3. "Хангүг вэгёса" II. ("Солонгосын гадаад харилцааны түүх") Дэд дэвтэр. Өмнөд Солонгосын улс төрийн гадаад харилцааны түүхийн нийгэмлэг. 1995. 4-р хэвлэл. Сөүл. Жибмүньдан Хэвлэлийн компани. 27-28-р тал.
4. Joseph Frankel, *The Making of Foreign Policy*, London: Oxford University Press, 1963, pp. 54-83.
5. Joseph Frankel, *International Relations*, (London: Oxford University Press, 1964), p. 55)
6. "Хангүг вэгёса" II. 29-р тал.
7. Дж. Гренвилл. "История XX века. Люди, события, факты." М. Аквариум. 1999. Стр-411. J.A.S. Grenville. *History of the World in the Twentieth Century*. HarperCollins Publishers.
8. Мөн тэнд